



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠠᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/355

Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Автотээврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалт, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2 дахь заалт, Зам тээврийн хөгжлийн сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний 4.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгаас автотээврийн салбарт баримтлах бодлогын баримт бичгийг хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Хурцгэрэл (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүн Л.Хаш-Эрдэнэ (Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Н.Пагмадулам (Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн мэргэжилтэн)

Д.Бат-Эрхэм (Автотээврийн төвийн автотээврийн хяналтын улсын байцаагч)

Нарийн бичгийн дарга: З.Жаргалтуяа (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

2.Аймгаас автотээврийн салбарт баримтлах бодлогын баримт бичгийг хүлээж авах ажлыг гэрээнд тусгагдсан нөхцөл болон холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг 2022 оны 06 дугаар сарын 15-ны дотор танилцуулахыг ажлын хэсэг (Г.Хурцгэрэл)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ

Г.ЧИНБАТ